

BRINKS ETHICS & COMPLIANCE

BRINK'S-ИЙН ХУДАЛДААНЫ ХОЛБООНЫ
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

2024 ОНЫ 11-Р САР

Агуулга

1.	ЗОРИЛГО БА ХЭРЭГЛЭЭ.....	3
2.	ХУДАЛДААНЫ ХОЛБОО.....	3
3.	ОРОЛЦОО БА ЗӨВШӨӨРӨЛ	4
4.	ХУДАЛДААНЫ ХОЛБООНЫ МАНЛАЙЛАЛ.....	4
5.	ХУДАЛДААНЫ ХОЛБООНЫ УУЛЗАЛТ	5
6.	ЗАРДАЛ	6
	ХАВСРАЛТ	7

1. Зорилго ба Хэрэглээ

Энэ бол Brink's компанийн ("Компани") бизнесийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэх харилцааг зохицуулах бодлогын баримт бичиг юм. Энэхүү Худалдааны Холбооны Бодлогын баримт бичгийн ("цаашид Бодлогын баримт бичиг гэх") зорилго нь Компанийн ажилтнууд ба түүний төлөөлөгчид дэлхий даяар мөрдөгдөж буй хууль тогтоомж, ялангуяа монополийн эсрэг буюу өрсөлдөөний хуультай холбоотой харилцаанд нийтлэг хууль тогтоомж болон Дэлхийн Монополийн Эсрэг бодлогыг дагаж мөрдөхүүлэхэд оршино.

Энэхүү бодлогын баримт бичиг нь Компанийн хамрах бүх бүс нутаг, хэлтэс мөн Компанийн нэрийн өмнөөс эсвэл төлөөлөн ажиллаж байгаа бүх ажилтнууд ба төлөөлөгчдөд хамаарна. Энэ баримт бичиг нь худалдааны холбоонд гишүүнээр элсэхийг хүсч байгаа эсвэл албан ёсны гишүүнчлэлгүйгээр оролцож байгаа бүх ажилчдад өөрийн нэрээр эсвэл Brink's-ийн нэр дор оролцож байгаа эсэхээс үл хамааран үйлчилнэ.

Brink's-д бид зөвхөн зөв зүйлийг хийдэг бөгөөд ёс зүйтэй бизнесийн практикт тууштай байх нь бидний үйл ажиллагааны үндсэн зарчим юм. Дэлгэрэнгүй мэдээллийг Brink's-ийн Ёс Зүйн Дүрэм болон Дэлхийн Монополийн эсрэг ба Шударга Өрсөлдөөний Бодлогын баримт бичгээс авч болох ба түүнийг Brink's-ийн дотоод сүлжээнээс буюу [ЭНДЭЭС](#) авах боломжтой. Хэрэв танд ямар нэгэн асуулт байвал, өөрийн Бүс Нутгийн Зөвлөлийн Захирал (RCD) эсвэл Бүс нутгийн Ерөнхий Зөвлөлтэй (RGC) холбогдоно уу.

Энэхүү Бодлогын баримт бичгийг зөрчсөн болох нь тогтоогдсон этгээдэд хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл сахилгын шийтгэл ногдуулж болно.

2. Худалдааны Холбоо

Худалдааны холбоо гэдэг нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой сэдвүүдийг хэлэлцэхээр цугладаг бүлэг юм. Худалдаа эсвэл үйлдвэрлэлийн холбоод нь (нийтэд нь худалдааны холбоод хэмээн нэрлэдэг) засгийн газрын өмнө хууль ёсны дагуу салбараа төлөөлөх, гишүүдэд мэргэжлийн мэдлэгээ өргөжүүлэх боломжийг олгох зэрэг үйлчилгээг үзүүлдэг. Тэд мөн үйлчлүүлэгчид ба борлуулагчдад Brink's-ийн үйлчилгээний саналыг танилцуулах платформыг санал болгож болно. Худалдааны танилцуулга нь зөвхөн энэхүү Бодлогын баримт бичгийн хүрээнд тодруулсан ба зөвшөөрөл авсан худалдааны холбооны гишүүдэд л нээлттэй байна.

Худалдааны холбоонд гишүүнчлэлтэй байх ба/эсвэл оролцоо нь хууль эрх зүйн асуудал үүсгэж болзошгүй; тэд ихэвчлэн өрсөлдөгчдийн дунд уулзалт зохион байгуулдаг бөгөөд худалдааны холбоод нь монополийн эсрэг болон өрсөлдөөний тухай хуулийг зөрчих эрсдэлтэй байдаг. Ийм төрлийн уулзалтуудад дараах хориотой сэдвүүдхөндөгдөх боломжтой. Хориотой сэдвүүд нь зөвхөн дараах асуудлаар хязгаарлагдахгүй. Үүнд:

- Үнэ, борлуулалтын тоо, нэмэлт хураамж, шимтгэл, хураамж болон бусад хураамж;
- Зардал, захын зай эсвэл ашиг;
- Төлбөрийн нөхцөлүүд;
- Үнийн арга барил эсвэл бизнес төлөвлөгөөнүүд;

- Тендер, зах зээл эсвэл үйлчлүүлэгчдийн сонголтууд;
- Худалдааны хязгаарлалт эсвэл нутаг дэвсгэрийн хуваарилалт;
- Нийлүүлэгчийн зөвлөмж; ба
- Бойкот хийх буюу "хар жагсаалтад" оруулах.

Худалдааны холбоод монополийн эсрэг болон өрсөлдөөний тухай хуулийг чанд дагаж мөрдөх шаардлагатай. Худалдааны холбоод болон өрсөлдөгчдийн хоорондын үйл ажиллагаа нь монополийн эсрэг хууль тогтоомжийн дагуу явагдах ёстой бөгөөд холбоод монополийн эсрэг эрх бүхий байгууллагын өмнө төлбөрийн хариуцлага хүлээнэ.

3. Оролцоо ба Зөвшөөрөл

Ажилтнууд худалдааны холбоонд доор дурдсанчлан цахим шуудангаар зөвшөөрөл авах хүртэл элсэх боломжгүй. Энэхүү Бодлогын баримт бичиг хэрэгжиж эхэлсэн өдрөөс өмнө үүссэн аливаа худалдааны холбооны гишүүнчлэл/оролцоо нь энэхүү Бодлогын баримт бичигт заасан бүх шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд доор дурдсанчланшаардлагын нийцлээ батлуулахаар ирүүлсэн байх ёстой. Ижил худалдааны холбоонд элсэхээр өмнө зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран ажилтан тус бүрийг нэг бүрчлэн хянан, баталгаажуулсан байх шаардлагатай.

Тодорхой худалдааны холбоонд гишүүнээр элсэх/оролцох нь зөвшөөрөгдсөн ажилтан Brink's-тэй байгуулсан харилцааг дуусгавар болгосон тохиолдолд түүний зөвшөөрлийг өөр ажилтанд автоматаар шилжүүлэхгүй. Ижил худалдааны холбооны шинэ гишүүн/оролцогч болох хүсэлтэй Brink's-ийн аливаа ажилтан дараах шаардлагыг хангаж, зөвшөөрөл авах үйл явцыг дагаж мөрдөх ёстой.

Харилцаа холбоогоо тэлэх зорилго нь худалдааны холбоонд элсэх хангалттай үндэслэл гэж үзэхгүй. Худалдааны холбооны үйл ажиллагаанд элсэхэд тулд ажилчид дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- I. Худалдааны Холбоонд элсэх өргөдлийг гаргах ба түүнийг Brink's-ийн дотоод сүлжээнээс [энд](#) олж болно.
- II. Brink's-ийн дэлхийн монополийн эсрэг болон өрсөлдөөний бодлогыг ойлгож, дагаж мөрдөхөө баталгаажуулах,
- III. хамгийн сүүлийн үеийн монополийн эсрэг сургалтыг дүүргэх,
- IV. улс орныхоо ерөнхий менежер эсвэл бүс нутгийн удирдагчаас бичгээр зөвшөөрөл авах, мөн
- V. RCD-ээс бичгээр зөвшөөрөл авах.

4. Худалдааны Холбооны Манлайлал

Худалдааны холбоонд манлайлах үүрэг гүйцэтгэхээр хандсан аливаа ажилтан компанид ямар үүрэг гүйцэтгэж байгаагаас үл хамааран дээр дурдсан зөвшөөрлийг бичгээр авах шаардлагатай. Brink's нь зөвхөн тодорхой ажилчдад компанийн нэрийн өмнөөс үг хэлэхийг зөвшөөрдөг. Brink's нь өөрийн нэрийн өмнөөс тайлбар хийх, аливаа төрлийн харилцаанд орох эрхийг зөвхөн тодорхой ажилтнуудад л олгодог. Ажилтан бүр өөрийн тайлбар, ажлын аливаа харилцаандаа Brink's-ийг төлөөлөх харилцаа үүсч байгаа эсэхэд ялгамжтай хандах үүрэгтэй. Тухайн ажилтанд худалдааны холбоодын үйл ажиллагаанд

оролцох зөвшөөрөл олгосон нь Brink's компанийн нэрийн өмнөөс үг хэлэх эрхтэй гэсэн үг биш юм.

Дэлгэрэнгүй зааварчилгааг [эндээс](#) Brink's-ийн сүлжээнээс олж болох ба Brink's-ийн ёс зүйн дүрэм, FD-ийн зохицуулалтын Бодлогын баримт бичиг, Дэлхийн Олон Нийтийн сүлжээнд баримтлах бодлогын баримт бичигтэй танилцана уу. Нэмж дурдахад, аливаа бичмэл материал эсвэл олон нийтэд хандсан мэдэгдэл нь хууль зүйн нийцлийн урьдчилсан хяналт, зөвшөөрөл авахыг шаардана..

5. Худалдааны Холбооны Уулзалт

Ажилчид худалдааны Холбоодын цуглаанд оролцохдоо монополийн эсрэг болон өрсөлдөөний хууль, Brink's-ийн бодлогыг зөрчихгүй байхад онцгой анхаарах ёстой. Холбогдох хууль тогтоомжийг зөрчих эрсдэлийг багасгахын тулд ажилчид доорх шаардлагыг дагаж мөрдөх ёстой бөгөөд уулзалтын үеэр эдгээр шаардлагаас гадуур ямар нэгэн зүйл тохиолдвол хуулийн асуудал хариуцсан албандхандах үүрэгтэй.

Уулзалтын өмнө

- Уулзалт болохоос өмнө хэлэлцэх асуудлын дарааллыг авч, орон нутгийн эсвэл бүс нутгийн хуулийн багт хянуулах. Хэрэв Худалдааны Холбоо одоогоор албан ёсны уулзалтын хэлэлцэх асуудлыг урьдчилж өгөөгүй бол оролцохоос өмнө тэднээс энэ журмын дагуу шаардлагаа тавина уу.
- Brink's дүрэм журмыг дагаж мөрдөхөд туслахын тулд дотооддоо зөвлөгөө өгөхийг илүүд үздэг боловч энэ нь үргэлж боломжгүй байдаг.
- Хурал зохион байгуулж буй этгээдээс монополийн эсрэг үндсэн зарчмууд болон хэлэлцэхийг хориглосон зүйлийн талаар товч сануулснаар эхлэх ёстой. (Хавсралтыг үзнэ үү)

Хурал цуглааны үеэр

- Бүх хурлыг дэлгэрэнгүй тэмдэглэлтэй байлгахыг хүснэ үү. Протокол тэмдэглэдэггүй хуралд оролцохгүй байх.
- Зөвхөн салбар/бизнесийн хууль ёсны сэдвүүдийг ярилцана уу. Аливаа компанийн бизнес төлөвлөгөө, үйлчлүүлэгчид, үнэ, зардал, ашиг, төлбөрийн нөхцөл, тендер, зах зээл, эсвэл тодорхой өрсөлдөгчдийг холбооноос гаргах талаар аливаа асуудал ярилцахыг хориглоно.
- Хэрэв оролцогчид дээр дурдсантай адил тохиромжгүй сэдвүүдийг хэлэлцэхийг оролдвол ажилтан тэднээс даруй зогсоохыг хүсэх үүрэгтэй. Хэрэв тэд тухайн асуудлыг үргэлжлүүлбэл ажилтан хурлыг орхиж, гарсан тухай мөн орхих болсон шалтгааны хамт хурлын тэмдэглэлд тэмдэглэхийг хүсэх үүрэгтэй. Ажилтан үүссэн нөхцөл байдлын талаар хуулийн багт яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
- Албан бус уулзалт, хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгагдаагүй яриа хэлцэлд оролцохыг хориглоно: ажилчид өрсөлдөгчтэйгээ уулзалтын тэмдэглэлгүй харилцахыг хориглоно. Өрсөлдөөнийг бууруулах, бизнесийн үйл ажиллагааг зохицуулах, өрсөлдөгчидтэй бизнесийн нийтлэг стратеги бий болгох утгааргойлгогдож болох аливаа зан үйлээс зайлсхийх үүрэгтэй.
- Монополийн эсрэг хууль болон Brink's-ийн монополийн эсрэг болон өрсөлдөөний талаар баримтлах глобаль бодлогын баримт бичгийг дотоод сүлжээнээс [эндээс](#)

олж болох бөгөөдэдгээр нь зөвхөн биечлэн хийх уулзалтаас гадна виртуал эсвэл утсаар зохион байгуулагдах уулзалтад нэгэн адил хамаарах бөгөөд эдгээр нь оройн хоол эсвэл ундаа, зөвхөн томоохон албан ёсны уулзалтууаас гадна жижиг, албан бус уулзалтуудад ч хамаарна.

Уулзалтын дараагаар

- Уулзалтын тэмдэглэлийн хуулбарыг Хуулийн албанд өгөх.
- Уулзалт дээр Brink's-ийн мэдээлэл авах хүсэлт ирсэн бол, ийм мэдээлэл өгөхөөс өмнө Хуулийн албанд хандах үүрэгтэй.

6. Зардал

Худалдааны Холбооны гишүүнчлэлтэй холбоотой гишүүнчлэлийн татвар, бусад зардлыг төлөх, эсвэл худалдааны холбооны аливаа хурал, арга хэмжээнд оролцох, бэлтгэхтэй холбоотой замын зардал болон бусад зардал түүнийг нөхөн төлөхтэй холбоотой хүсэлт гаргахын тулд ажилтнууд урьдчилан тэдний RCD-ээс Худалдааны Холбоонд оролцох өргөдлөө гаргаж, бичгээр зөвшөөрөл авах ёстой.

Хавсралт

Уулзалтын тухай сануулга

[Худалдааны холбооны нэр]-ийн гишүүд [ба зочдын нэрс] бид монополийн эсрэг хууль тогтоомжийн хязгаарлалтыг анхаарч үзэх хэрэгтэй.

Зарчмын хувьд өрсөлдөөнийг хязгаарлах аливаа төрлийн гэрээ хэлэлцээр, хууиар хориглосон үйл ажиллагааны талаар талуудын хооронд эсвэл бидний дунд ямар ч хэлэлцүүлэг байх ёсгүй.

Үүнд тухайн компанийн одоогийн болон ирээдүйн үнэ, үнийн түвшин, үнийн томъёолол, хөнгөлөлт, зардал, борлуулалтын нөхцөл болон үнэд нөлөөлж болох бусад зүйлсийн талаар зохисгүй мэдээлэл солилцох зэрэг орно.

Цаашилбал, бид арилжааны стратеги, худалдан авагч ба борлуулагчидтай харьцахаас татгалзах, зах зээлийн хуваарилалт, үйлчлүүлэгчийн хуваарилалт, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл аливаа оролцогчийг өрсөлдөөний үйл ажиллагаагаа нэг буюу хэд хэдэн оролцогчийн хүрээнд өрсөлдөөний үйл ажиллагаагаа зохицуулахаар тохиролцоход хүргэж болзошгүй бусад сэдвүүдийн талаар ярихаас зайлсхийх ёстой.

Манай худалдааны холбоодын хурлаар хэлэлцсэн асуудалд талуудын хандсан байр суурь нь заавал дагаж мөрдөх шинжтэй бус байх ба ; компани тус бүр бүр аль ч холбооны үзэл бодлоос үл хамааран салбарын хэмжээний асуудалдаа өөрин байр сууринаас оролцох эрх нь нээлттэй хэвээр байна.

Та бүхэн аливаа асуудалд бие даасан дүгнэлт хийж, аль болох өрсөлдөгчтэй хуувилдсан мэт харагдах аливаа үйлдлээс зайлсхийх эрхтэй. Хэрэв танд асуулт, санал байгаа бол [худалдааны холбооны ерөнхий зөвлөх] [таны компанийн зөвлөх]-өөсөө эргэлзэлгүй хуулийн зөвлөгөө аваарай..